

Монгол Улсын Засгийн газар COVID-19-ийн халдвар тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эртнээс эрчимтэй авч эхэлсэн. Боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг 1-р сарын 27-ноос эхлэн албан ёсоор зогсоож, коронавирусын халдвар илэрсэн улсууд руу зорчих аялалын хориг тавьсан төдийгүй 2-р сарын 13-нд Монгол улс онцгой байдлын өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн. Мөн 2020 оны 2-р сарын 24-26-ний өдрүүдэд тохиосон Сар шинийн баярын үеэр коронавирусын халдвар гарах болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын Онцгой Комиссоос хот хоорондын зорчих хөдөлгөөнийг хориглох шийдвэр гаргасан. Нийслэл Улаанбаатар хот хүн амын төвлөрөл ихтэй, Монгол улсын нийт хүн амын тэн хагас нь оршин суудаг. Үүгээр зогсохгүй, Улаанбаатар хотоор дамжин зорчих хөдөлгөөн их тул коронавирусын халдварыг улс даяар тараах эрсдлийн хамгийн том хүчин зүйлсийн нэг болж байна. Эрсдлийн бэлэн байдлыг цаг ямагт хангаж, коронавирус илэрсэн үед авах арга хэмжээг чанаржуулахын тулд, иргэдийн орж, гарах урсгалын талаарх бүртгэл мэдээллийг сайжруулах ажлыг Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар (НЗДТГ), Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ)-ын Монгол дахь салбарын техник туслалцаатайгаар хэрэгжүүлж байна. НЗДТГ болон ОУШХБ-ын хамтын ажиллагааны дагуу мэдээлэл цуглуулах ажилд 300 гаруй эмнэлгийн болон боловсролын салбарын ажилтныг дайчлан хамруулж, ДТМ аргачлалд сурган, хэрэгцээт зөвлөмж, техникийн туслалцаагаар ханган ажиллаж байна. Хот хоорондын хөдөлгөөн хязгаарлалттай үед буюу 2-р сарын 27-ны 08 цагаас 3-р сарын 3-ны 06 цаг хүртэл урсгал хөдөлгөөнийг хянах ажлын туршилтын үе хийгдэж, үүнээс хойш 5-р сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжилнэ. Нийслэлийн ойролцоох 6 (Эмээлт, Баруунтуруун, Гүнт, Өлзийт, Морин, Налайх) шалган нэвтрүүлэх товчоод дээр тээврийн хэрэгслийн төрөл, зорчигчдын тоо, хүйс, зорчин явж буй чиглэлийн талаарх мэдээллийг 24 цагийн турш иргэдээс авч байна. Хэдийгээр ДТМ аргачлалыг нийслэл хотод анх удаа ашиглаж байгаа боловч дэлхийн 80 гаруй улсад онц байдлын үед ашигладаг ба зөвхөн 2018 онд л гэхэд 40 сая гаруй хүнийг хамруулжээ. Мөн 2018 онд Өмнөд Судан улсад Эбола вирус тархах үеэр иргэдийн хөдөлгөөнийг тандах зорилгоор ДТМ аргачлалыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Монгол улсын хувьд Онцгой Байдлын Ерөнхий Газар, ОУШХБ хамтран 2018 оноос хойш 21 аймаг, 330 сумд дахь иргэдийн хөдөлгөөнийг баримжаалан тандаж байгалийн гамшиг, тэр дундаа зудын нөхцөл үүссэн үед ажиллах бэлтгэл ажлыг хангах зорилгоор уг аргачлалыг хэрэглэж ирсэн.

### ТОЙМ ТОО

**1,382,860**

Хөдөлгөөний нэмэгдсэн дүн ДТМ (УХЦ)  
урсгал хянасан хөдөлгөөний цэгээр хянасан.

**52,584** ↓

Сүүлийн 24 цаг  
бүртгэгдсэн хөдөлгөөн

**10,196 (X)**

**43,663 (Ч)**

Зорчих хөдөлгөөн хориотой (X) болон  
чөлөөтэй (Ч) үеийн өдрийн дундаж хөдөлгөөн

### ХҮН АМ ЗҮЙ

XX% - Нийт

XX% - Сүүлийн 24 цаг



ЭРЭГТЭЙ **47%**



ЭМЭГТЭЙ **33%**




ХҮҮ **11%**




ОХИН **9%**

### ХҮНИЙ ХӨДӨЛГӨӨН (НИЙТ)



### ХӨДӨЛГӨӨНИЙ ЧИГЛЭЛ




### ТОВЧООД ДЭЭРХ ХӨДӨЛГӨӨНИЙ УРСГАЛ

Товчоо	НИЙТ			2020-4-5		
	НИЙТ	Орсон	Гарсан	НИЙТ	Орсон	Гарсан
Эмээлт	309,372	148,857	160,515	3,351	1,853	1,498
Баруунтуруун	203,480	102,876	100,604	4,743	2,693	2,050
Налайх	421,507	211,242	210,265	24,728	11,701	13,027
Морин	298,346	149,356	148,990	17,875	8,956	8,919
Өлзийт	464,801	252,684	212,117	12,550	7,176	5,374
Гүнт	199,270	99,951	99,319	15,945	8,078	7,867
<b>НИЙТ</b>	<b>1,896,776</b>	<b>964,966</b>	<b>931,810</b>	<b>79,192</b>	<b>40,457</b>	<b>38,735</b>



## УЛААНБААТАР РУУ ЧИГЛЭСЭН ХӨДӨЛГӨӨН



### Legend


УБ-т очих дүүрэг

- 5,461 - 21,611
- 21,612 - 45,410
- 45,411 - 88,077
- 88,078 - 201,641
- 201,642 - 262,208

Гарсан аймаг

- 1,190 - 9,298
- 9,299 - 21,371
- 21,372 - 31,416
- 31,417 - 162,052
- 162,053 - 514,169

- Улсын хил
- Гол зам



Энэхүү зураглалд ашигласан хил, хязгаар, нэр, нэршил нь албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөнийг илтгэхгүй болно

## ХҮН АМ ЗҮЙ

XX% - Нийт

XX% - Сүүлийн 24 цагт



ЭРЭГТЭЙ

51%

46%



ЭМЭГТЭЙ

32%

33%



ХҮҮ

9%

12%




ОХИН

8%

9%

Улаанбаатарт очсон дүүрэг	?	Багахангай	Багануур	Баянгол	Баянзүрх	Чингэлтэй	Хан-Уул	Налайх	Сонгинохайрхан	Сүхбаатар	НИЙТ
Улаанбаатар	1,707	4,391	15,336	31,682	70,578	21,318	148,060	43,155	156,140	21,802	514,169
Архангай	105	12	49	4,174	5,310	1,696	2,611	127	8,209	1,514	23,807
Баянхонгор	54	10	38	1,556	2,450	763	1,137	91	4,194	846	11,139
Баян-Өлгий	6	-	-	156	289	47	58	10	504	120	1,190
Булган	134	18	35	3,280	4,414	1,319	2,342	68	5,417	1,118	18,145
Дархан-Уул	184	33	97	5,060	6,112	1,679	3,538	272	12,437	2,004	31,416
Дорнод	46	5	2	856	3,768	566	850	32	962	693	7,780
Дорноговь	47	14	21	2,103	4,657	593	1,377	56	1,694	890	11,452
Дундговь	58	3	17	2,180	4,849	793	2,637	17	2,685	1,084	14,323
Говь-Алтай	23	11	31	652	1,136	310	439	19	1,871	332	4,824
Говьсүмбэр	28	5	25	1,467	4,702	444	924	48	933	722	9,298
Хэнтий	54	6	20	1,873	10,474	1,138	1,705	44	1,856	1,410	18,580
Хөвд	5	-	12	547	1,013	252	571	40	1,841	143	4,424
Хөвсгөл	55	25	71	2,290	2,988	761	1,500	62	4,185	824	12,761
Орхон	88	4	70	4,031	4,860	1,099	3,086	169	6,413	1,551	21,371
Сэлэнгэ	111	26	112	6,846	7,318	2,146	3,644	290	8,442	2,296	31,231
Сүхбаатар	42	5	15	602	3,530	289	478	43	558	450	6,012
Төв	730	114	351	25,677	34,663	11,326	28,127	1,044	48,020	12,000	162,052
Өмнөговь	88	5	34	2,583	4,619	897	4,510	65	4,500	1,064	18,365
Өвөрхангай	122	51	69	4,260	5,636	1,734	3,650	155	9,977	1,511	27,165
Завхан	42	10	12	1,324	2,226	494	963	45	2,518	630	8,264
Увс	18	5	18	634	1,292	317	549	87	2,154	293	5,367
?	29	4	7	263	535	82	271	146	413	148	1,898
<b>НИЙТ</b>	<b>3,776</b>	<b>4,757</b>	<b>16,442</b>	<b>104,096</b>	<b>187,419</b>	<b>50,063</b>	<b>213,027</b>	<b>46,085</b>	<b>285,923</b>	<b>53,445</b>	<b>965,033</b>

### УЛААНБААТАРААС ГАРСАН ХӨДӨЛГӨӨН



Энэхүү зураглалд ашигласан хил, хязгаар, нэр, нэршил нь албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөнийг илтгэхгүй болно

### ХҮН АМ ЗҮЙ

XX% - Нийт

XX% - Сүүлийн 24 цагт



ЭРЭГТЭЙ

51%

49%



ЭМЭГТЭЙ

30%

32%



ХҮҮ

10%

10%



ОХИН

9%

9%

Улаанбаатараас гарсан дүүрэг	?	Багахангай	Баянзүрх	Багануур	Баянгол	Чингэлтэй	Хан-Уул	Налайх	Сонгинохайрхан	Сүхбаатар	НИЙТ
Арханагай	290	4	3,926	36	2,916	1,342	1,994	122	7,018	1,171	18,819
Баянхонгор	85	3	1,420	68	1,172	550	960	58	3,797	563	8,676
Баян-Өлгий	-	-	272	-	200	34	69	1	453	67	1,096
Булган	197	1	3,392	23	2,704	1,228	1,914	25	5,330	946	15,760
Дархан-Уул	111	13	5,102	66	4,208	1,509	3,093	214	14,577	1,638	30,531
Дорнод	44	8	4,193	2	731	566	855	18	803	560	7,780
Дорноговь	49	5	5,732	44	2,264	883	1,736	39	1,805	889	13,446
Дундговь	59	17	4,797	42	1,878	875	2,594	40	2,910	1,132	14,344
Говь-Алтай	31	9	736	18	301	204	376	39	1,808	182	3,704
Говьсүмбэр	25	-	4,450	13	1,138	519	820	39	946	577	8,527
Хэнтий	87	8	10,478	17	1,736	972	1,367	44	1,629	1,282	17,620
Ховд	11	-	738	7	384	128	366	38	1,571	164	3,407
Хөвсгөл	58	3	1,887	16	1,182	486	1,107	52	3,986	519	9,296
Орхон	113	9	3,823	85	3,540	1,110	2,652	129	7,196	1,200	19,857
Сэлэнгэ	64	15	6,151	123	6,090	1,872	3,385	353	8,983	1,915	28,951
Сүхбаатар	28	6	3,576	2	451	322	516	17	638	567	6,123
Төв	965	78	32,995	372	23,820	10,791	26,666	1,117	48,237	11,380	156,421
Өмнөговь	56	15	5,717	79	2,988	1,248	5,089	105	5,403	1,729	22,429
Увс	26	7	633	18	278	189	302	27	1,279	166	2,925
Өвөрхангай	208	21	3,994	53	3,107	1,106	2,650	60	8,527	1,207	20,933
Завхан	70	5	1,168	14	714	317	576	52	2,220	296	5,432
?	73	1	354	37	179	115	173	196	524	98	1,750
<b>НИЙТ</b>	<b>2,650</b>	<b>228</b>	<b>105,534</b>	<b>1,135</b>	<b>61,981</b>	<b>26,366</b>	<b>59,260</b>	<b>2,785</b>	<b>129,640</b>	<b>28,248</b>	<b>417,827</b>